

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ**

2021 оны 02 дугаар сарын 01

Дархан

1. Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын талаар

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, танилцуулгыг аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлж, гарсан саналыг тусган, Засгийн газрын цахим санд баталгаажуулалтыг хийж, аймгийн Засаг даргын 2021.01.12-ны өдрийн 1-10/25 тоот албан бичгээр ЗГХЭГ-т цахим болон хэвлэмэл хэлбэрээр хугацаанд нь хүргүүлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2020 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, танилцуулгыг Засаг даргын зөвлөлийн 2020.01.27-ны өдрийн 02 дугаар хуралдаанаар танилцуулж, ЗГХЭГ-ын цахим санд оруулж, баталгаажууллаа. Хэвлэмэл байдлаар аймгийн Засаг даргын 2021.01.28-ны өдрийн 1-10/88 тоот албан бичгээр хугацаанд нь (02 сарын 01-ны өдрөөс өмнө) ЗГХЭГ-т хүргүүлээ.

Үндэсний хөтөлбөрийн 2020 оны биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж холбогдох яамдуудад хүргүүлсэн тайлангууд. Үүнд:

1. Эрүүл мэндийн яаманд 11 үндэсний хөтөлбөрийн 105 хуудас тайлан аймгийн Засаг даргын орлогчийн 2021.01.26-ны өдрийн 1-10/74 дүгээр албан бичиг,

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд 9 үндэсний хөтөлбөрийн 40 хуудас тайлан аймгийн Засаг даргын орлогчийн 2021.01.28-ны өдрийн 1-10/85 дугаар албан бичиг,

3. Хууль зүйн дотоод хэргийн яаманд 5 үндэсний хөтөлбөрийн 25 хуудас тайлан аймгийн Засаг даргын орлогчийн 2021.01.26-ны өдрийн 1-10/70 дугаар албан бичиг,

4. Боловсрол шинжлэх ухааны яаманд 3 үндэсний хөтөлбөрийн 15 хуудас тайлан аймгийн Засаг даргын орлогчийн 2021.01.26-ны өдрийн 1-10/72 дугаар албан бичиг,

5. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 12 үндэсний хөтөлбөрийн 54 хуудас тайлан аймгийн Засаг даргын орлогчийн 2021.01.26-ны өдрийн 1-10/76 дугаар албан бичиг,

6. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд 6 үндэсний хөтөлбөрийн 45 хуудас тайлан аймгийн Засаг даргын орлогчийн 2021.01.28-ны өдрийн 1-10/86 дугаар албан бичиг,

7. Эрчим хүчний яаманд 1 үндэсний хөтөлбөрийн 4 хуудас тайлан аймгийн Засаг даргын орлогчийн 2021.01.26-ны өдрийн 1-10/75 дугаар албан бичиг,

8. Соёлын яаманд 3 үндэсний хөтөлбөрийн 12 хуудас тайлан аймгийн Засаг даргын орлогчийн 2021.01.26-ны өдрийн 1-10/71 дүгээр албан бичиг,

9. Стандарт хэмжилзүйн газарт 1 үндэсний хөтөлбөрийн 11 хуудас тайлан аймгийн Засаг даргын орлогчийн 2021.01.26-ны өдрийн 1-10/73 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 27 агентлаг, 4 сумын ЗДТГазар, нийт 31 байгууллагын “**2020 оны гүйцэтгэлийн тайлан**”-г уншиж, нэгдсэн үнэлгээг 4 шалгуур үзүүлэлтийн хүрээнд гаргалаа.

№	Байгууллага	Ерөнхий дундаж үнэлгээ	Тайлбар
Нэг. Сум-4			
1.	Дархан сумын ЗДТГ	85.96%	
2.	Хонгор сумын ЗДТГ	92.67%	
3.	Шарын гол сумын ЗДТГ	84.46%	
4.	Орхон сумын ЗДТГ	85.44%	
Хоёр. Агентлаг-27			
1.	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	96.61%	
2.	Биеийн тамир, спортын газар	94.75%	
3.	Боловсрол, соёл, урлагийн газар	83.27%	
4.	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	89.75%	
5.	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	99.33%	
6.	Мэргэжлийн хяналтын газар	99.45%	
7.	Онцгой байдлын газар	92.59%	
8.	Орон нутгийн өмчийн газар	92.89%	
9.	Санхүүгийн хяналт, аудитын алба	95.88%	
10.	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	99.55%	
11.	Статистикийн хэлтэс	99.20%	
12.	Татварын хэлтэс	70.0%	
13.	Улсын бүртгэлийн хэлтэс	98.80%	
14.	Ус, цаг уур, орчны шинжилгээний алба	99.64%	
15.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	97.31%	
16.	Хүнс, хөдөө аж ахуйн газар	97.20%	
17.	Эрүүл мэндийн газар	96.16%	
18.	Нийгмийн даатгалын хэлтэс	96.42%	
19.	Автотээврийн төв	-	
20.	Мэдээлэл, технологийн алба ОНӨААТГ	99.13%	
21.	Захирагчийн алба	83.42%	
22.	Нийтлэг үйлчилгээний алба	-	
23.	Нийтийн аж ахуй үйлчилгээний газар	82.25%	
24.	Дархан-Хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ	98.98%	
25.	Дархан орон нутгийн зам, тээвэр ОНӨААТГазар	88.98%	

26.	Мал эмнэлгийн газар	97.98%	
27.	Сум дундын ойн анги	96.50%	
Аймгийн хэмжээнд дундаж		92.91%	

Урьдчилсан үнэлгээгээр: 29 байгууллагаас 99-95.0% үнэлгээгээр-16, 90-94.0% үнэлгээгээр-4, 85-89.0% үнэлгээгээр-4, 80-84.0% үнэлгээгээр-4, 70-74.0% үнэлгээгээр-1.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 15 агентлаг, 4 сумын ЗДТГазар, төрийн өмчийн ЕБС-9, СӨББ-26, соёл-урлагийн 4 байгууллага, нийт **58 байгууллагын** 2020 оны үйл ажиллагааны ХШҮ-ний 58 тайланг нэг бүрчлэн уншиж, ололт амжилт, тулгамдсан асуудал, судалгаа шинжилгээний ажлуудын нэгтгэлийг гүйцэтгэлээ. Үүнд:

№	Байгууллага	Ололт амжилтын тоо	Судалгаа шинжилгээний тоо	Тулгамдсан асуудлын тоо
1.	Сум, агентлаг	44	12	25
2.	ЕБС	22	44	13
3.	СӨББ	59	76	104
4.	Соёл-урлагийн байгууллага	4	2	13
Бүгд		129	134	155

Аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилтэд 2020 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд аймгийн ИТХ-ын хуралдааны 12 тогтоолын биелэлт 91.43% буюу 4.57 оноо, Тэргүүлэгчдийн хурлын 42 тогтоолын биелэлт 95.36% буюу 4.77 оноо, нийт 54 тогтоолын ерөнхий дундаж үнэлгээ 95.42% буюу 4.77 онооны үзүүлэлттэй байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 9 тогтоол

“бүрэн хэрэгжсэн”-100.0% - 6 тогтоол (ТЗУХ-1, ХОХБТХ-2, СТСХ-3),
“хэрэгжих шатанд”-70.0% - 1 тогтоол (ОНӨГ-1)
“хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” - 4 тогтоол (ТЗУХ-1, СТСХ-1, ХОХБТХ-2),
“үнэлэх боломжгүй” – 1 тогтоол (ОНӨГ-1)

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 42 тогтоол

“бүрэн хэрэгжсэн”-100.0% - 36 тогтоол,
“хэрэгжих шатанд”-70.0% - 4 тогтоол,(58,68,105,106)
“хэрэгжилт хангалтгүй”-30.0% - 1 тогтоол (06),
“хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” -1 тогтоол (96) байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулгыг Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар (2021.01.12) аймгийн Засаг даргад хэрэгжүүлэхээр үүрэг болгож хяналтад авсан 54 тогтоолын биелэлтэд 94.79% үнэлгээтэйгээр танилцуулан хэлэлцүүлж хэрэгжих шатанд болон хэрэгжилт хангалтгүй үнэлгээтэй тогтоолуудыг дахин сайн нягтлах талаар чиглэл өгсний дагуу Татварын алба, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцлага зохион байгуулж чанарын үнэлгээ хийснээр бичил бизнес эрхлэгчдээс авах татварын хувь хэмжээг

тогтоох тухай тогтоолын үнэлгээ өсч ерөнхий үнэлгээ 95.42 хувиар үнэлэгдэж аймгийн Засаг даргын орлогч А.Түвшинбатад танилцуулан, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд (2021.01.15) танилцууллаа.

2. Онцгой байдал

“Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Онцгой байдлын газрын даргын 2020 оны А/115 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг боловсруулан Онцгой байдлын газрын дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нарын бичгийн даргад хянуулан 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар танилцуулан батлуулсан.

“Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн хүрээнд Галын аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж боловсруулан Дархан сумын Засаг дарга, Онцгой байдлын газрын дарга нарт танилцуулан батлуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

2020-2021 онд аймгийн хэмжээнд өвөлжиж хаваржих малчин өрх, малчин хүүхдийн тоог сумдаас авч нэгтгэн Улсын Онцгой комиссын ажлын албанд хүргүүлсэн.

Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан хүргүүлсэн.

Аймгийн Онцгой комиссын шуурхай штабд зарим мэргэжилтнүүд үүрэг гүйцэтгэж Коронавирусээс урьдчилан сэргийлэх тэмцэх чиглэлээр аймгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар ханган нэгдсэн тайлан мэдээг гаргаж Улсын Онцгой комиссын Шуурхай штаб, Хойд бүсийн төв, аймгийн Онцгой комиссын даргыг мэдээ мэдээлэлээр ханган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 194 дүгээр тогтоолын хавсралтын дагуу аймгийн Шуурхай штабаас холбогдох журмын дагуу бичиг баримтыг үндэслэн 872 нэвтрэх зөвшөөрөлийг 1909 иргэнд олгож ажилласан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/04 “Норм батлан шинэчлэн батлах тухай тушаалын хэрэгжилтийг хангуулж, ГУАМашин-15, Шуурхай албаны-15 машины жолоочийн тооцоог шинэ нормчлалаар бодохыг техникийн ахлах, жолооч нарт танилцуулсан.

2020 оны 12 дугаар сард Алтанбулаг боомтоор орж ирсэн 19 иргэний төлбөрийн мэдэгдэх хуудсыг Таталбар ХХК ны Хаан банкин дахь 5046388072 дансруу хийх, ОБЕГ-ын дансанд орсон 2 иргэний 1,400,000 төгрөг, дутуу төлсөн 1 иргэний 160,000 төгрөг нийт 1,560,000 төгрөгийг ОБЕГ-ын хөрөнгө оруулалтын газарт нэхэмжлэх илгээн тус компани дансанд шилжшүүлэн ажилласан. Засгийн газрын 2020 оны 133 тогтоолын хавсралт Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журамын дагуу 2021 оны 01 дүгээр сард Дархан-уул аймгийн Дархан сумын 3-р багийн Ахмадын хорооны “Түм бум хуримтлалын бүлгээс 100,000 төгрөг мөнгөн хандив, Амгаланзаяа ХХК-с 13 нэр төрлийн 613,500 төгрөгийн эмийн ургамалтай зэхмэл, Иргэн Н.Рэнцэнсамбуу хонь, ямааны гулууз мах тус тус 1ш 243,000 төгрөг нийт 956,500 төгрөгийн хандив материал хүлээн авч ажилласан.

Энэ сард аймгийн хэмжээнд аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 2 удаагийн шалгалт явуулж нийт 35 байгууллага хамрагдсанаас гал түймэр, гамшиг ослын аюулд хүргэж болзошгүй 45 зөрчил илэрснээс газар дээр нь 58 зөрчлийг арилгуулан, хөрөнгө мөнгө, цаг хугацаа шаардсан бусад зөрчлийг арилгуулахаар Заавал биелүүлэх албан шаардлага-8, мэдэгдэл-35 бичиж, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар заавар зөвлөгөө өгч ажиллаа. ОБЕГ-ын даргын 2013 оны А/494 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Гамшгаас хамгаалах асуудлаар гарсан Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Тушаал, шийдвэр, Засгийн газрын тогтоол, Шадар сайдын, болон ОБЕГ-ын даргын тушаал, албан даалгавар, үүргийн биелэлтийн тайлан мэдээг маягт-ГМ-17.1, маягт-ГМ-17.2-ийн дагуу, Аюулт үзэгдэл, ослын хохирлын нэгдсэн мэдээг маягт-ГМ-1-19-ийн дагуу нэгтгэж хянуулан ажиллалаа.

Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт **2**-ыг иргэн, ААНБ-д олгож **25,000** төгрөг, барилгын зураг төсөл **3** удаа хянаж тэмдэгтийн хураамж **250.000** төгрөг, нийт төлбөр хураамж **275,000** төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажиллалаа.

Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын 3 дахь хавсралтын дагуу гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж байгаа 10 дугаар цэцэрлэг, Төмөр зам зэрэг 3 аж ахуйн нэгж байгууллагын ажилтан албан тушаалтанд заавар зөвлөмж өгсөн.

Онцгой байдлын газрын даргын баталсан “Цахилгаан хэрэгслийн гал түймэр”-ийн аюулаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжаар ГТУА 22, 54, 55-р ангид чиглэл өгч хамтран Дархан сумын 1-3 дугаар багийн Цахир, Барилгачин, Чулуут, Партизан, Цэнгэлдэх, Пионер, Октябрь, Хушаат, Ухаа хошуу, Тосгон, Ажилчин, Малчин, Улиастай, Угалз, Цант, Булагт, Хараа, Уужим булаг, Цагаан үнээний ферм, Мангиртын 9 дүгээр хэсэг/, Дархан сум 7 дугаар баг /Майхант, Замчин, Сэргэлэн, Түлээт, Зурагт, Зурагтын ар, Хангамж/, 5-р багийн Хүнсчид, Залуучууд, Цагааннуур, Дархан сум 6 дугаар багийн Ханжаргалант, Тээвэрчид, Баяндаваа, 5, 8 дугаар баг /Нарантолгой, Манхантолгой, Дэвшил, Залуучууд, Цагааннуур, Үйлдвэр, Хүнсчид, Шарын гол сумын Дархан баг, Уурхайчдын 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дугаар гудамжны айл өрхүүд, Санжинт баг Ойчидын 1, 2, 3, 4, 5, 6, 7, 9, 10, 11, 12, 13 дугаар гудамж, Ойн 1, 2 дугаар гудамж, Тосгоны 10, 11, 12 дугаар гудамж, Санжинт баг Ойчидын 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19 дүгээр гудамж, Тайгын 1, 2 дугаар Хоккейчдын 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дугаар Бага Дарханы ар, өвөр Шаазгайтын гудамжны айл өрхүүдэд галын аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааг 2021.01.05-2021.01.15-ний өдрийн хугацаанд зохион байгуулж ард иргэдэд заавар зөвлөгөө өгч ажилласан.

Галын аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаанд нийт 605 айл өрх, **2914** иргэн хамрагдсан байна. Үзлэг шалгалтаар илэрсэн 61 зөрчлийг арилгах сануулга заавар зөвлөгөө өгч ажилласан.

Гамшгийн шуурхай удирдлагын газраас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр ирүүлсэн үүргийн хүрээнд 2020 оны 12 дугаар сарын 25-наас 26-ны өдрүүдэд RGB,

DBS телевиз, 98.9, 106.5, 104,5, 90,8 ФМ, Орон нутгийн хэвлэл мэдээллийн ажилтан нарын дунд байгуулсан шуурхай мэдээлэл дамжуулах “Дархан сурталчилгааны алба” цахим чат группт цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээллийг байршуулан иргэд олон нийтэд сурталчлах талаар үүрэг чиглэл өгч Монголын үндэсний олон нийтийн телевиз, Дархан сумын 18 багийн фэйсбүүкт буюу нийт 20 цахим хуудсанд цаг агаарын анхааруулга мэдээллийг байршуулан иргэдэд түгээсэн. Аймгийн хэмжээнд 20688 малчинд, утсаар-265 ирэнд, багц мессежээр 1302 иргэнд нийт 22255 иргэнд цаг агаарын анхааруулах мэдээллийг тус тус хүргэн ажилласан.

Монгол Улсын Онцгой комиссын 2020 оны 04 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 01-А/351 дүгээр захирамжийн биелэлтийг хангах ажлын хүрээнд 2 удаагийн нэгдсэн арга хэмжээ, 1 удаагийн хяналт, шалгалт зохион байгуулж, 42 удаагийн шууд нэвтрүүлэгт оролцож, 4 телевиз, 4 ФМ, 2 лед дэлгэц, da.nema.gov.mn, Онцгой байдлын газар, Дархан-Уул аймаг, Дархан хот, www.da.mohs.gov.mn веб хуудас 5 цахим хуудсаар амны хаалт зүүх, гараа угаах талаар нийт 32 төрлийн сурталчилгааг 14186 удаа иргэд олон нийтэд түгээсэн байна.

Онцгой байдлын ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын даргын 2021 оны 03/27 дугаар албан бичгийн хэрэгжилтийг хангуулан Онцгой байдлын газрын илүүдэл жинтэй 21 албан хаагчийн судалгаа гаргаж цахимаар болон албан бичгээр хүргүүлсэн. Мөн спортын цол, зэрэг жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй, бусад шалтгаантай алба хаагчдын судалгааг хавсралтаар гаргасан.

Онцгой байдлын газраас 2020 оны 11 дүгээр сараас эхлэн тусгаарлах байранд үүрэг гүйцэтгэсэн 9 алба хаагчийн, тусгаарлалтад орсон 4 алба хаагчийн судалгааг гаргаж танилцуулсан.

Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ээр сургалт зохион байгуулж шүүлэг авахад дараах дүн мэдээтэй байна.

д/д	Шүүлгийн төрөл	Дүн	1 сар
1	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн шүүлэг	Онц	15
		Сайн	34
		Дунд	17
2	Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрмийн шүүлэг	Онц	14
		Сайн	28
		Дунд	16
3	Гал түймэр унтраах дүрмийн шүүлэг	Онц	12
		Сайн	33
		Дунд	28
4	Гал унтраах дасгал сургуулийн нормативын шүүлэг	Онц	19
		Сайн	35
		Дунд	12

Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын байцаагч нар нийт 2 зөрчлийн хэргийг шалган хялбаршуулсан журмаар шийдвэрлэж аймгийн прокурорын газарт хянуулан ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 30, 32, 138 дугаар тогтоол, ОБЕГ-ын даргын 2015 оны А/182 дугаар тушаал “ОБА-ны цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”-ын дагуу алба хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийн сүлжээ, системийн найдвартай ажиллагаа, төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, гадна болон дотоодоос учирч болох халдлага, аюул заналаас хамгаалах, эрсдэлийг бууруулах, интернетийн зохистой хэрэглээг бий болгох, хариуцлагыг нэмэгдүүлж ажилласан.

Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэн хурлын дэлгэц 55 инч 4 ширхэг, Авег цахим хурлын төхөөрөмж 1 ширхэг, компьютер 1 ширхэг, АЗ-ийн өнгөт хэвлэгч 1 ширхэг, хэт богино долгионы радио станц 2, хуваарилагч төхөөрөмж 1 ширхэг, өсгөгч 1 ширхэг, чанга яригч 2 ширхэг, нийт 11 нэгж техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 155 дугаар тушаалын дагуу гэрийн ажиглалтад шилжсэн иргэдийн зорчих хөдөлгөөнийг цахим хэлбэрээр хянах “CLIX GPS” системийг хариуцах 4 сумын 8 албан тушаалтанд 2 цагийн сургалт зохион байгуулж үйл ажиллагаандаа нэвтрүүлээ. Мөн дээрх албан хаагчдын судалгааг Улсын Онцгой комисст хүргүүлсэн.

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомт болон хээрийн нөхцөлд үүрэг гүйцэтгэх үеийн “Хөдөлгөөнт удирдлагын байр”-ыг Камаз АСМ 48-03 загварын автомашинд тулгуурлан байгуулж автомашинд байршуулах тоног төхөөрөмжийг Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч Н.Төрбат, Гал түймэр унтраах, аврах 22-р ангийн Гал унтраах автомашины жолооч, ахлах ахлагч Н.Батзаяагийн хамт Улаанбаатар хотоос татан авах ажлыг 2020 оны 12 дугаар сарын 09, 10-ны өдөр “Нарны буман гэрэл” ХХК, “Mon Vsat” ХХК, “IT care” ХХК, “Номин” электроникс ХХК-уудаас 32 инчийн дэлгэц-1ш, Сансрын холбооны терминал, нарны зайн систем, РТЗ камер, хөргөгч болон 100 айлын барилгын материалын төвийн агуулахаас дотор тохижилт материал буюу нийт 82 төрлийн 10.563.000 төгрөгийн бараа материалыг татан авч автомашинд суурилуулсан.

“Хөдөлгөөнт удирдлагын байр” нь Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аюулт үзэгдэл, ослын үед Онцгой байдлын ерөнхий газар, Хойд бүсийн Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвтэй холбогдон мэдээ, мэдээллийг түргэн шуурхай хүлээн авах, дамжуулах, хариу арга хэмжээ авах, удирдлага зохион байгуулалтаар бүрэн хангах, алба хаагчдыг ая тухтай орчинд үүрэг гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэн албаны бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүллээ.

Гамшгийн үед Монгол орны аль ч цэгээс холбогдож яриа болон дата дамжуулах MonVsat сансрын холбооны төхөөрөмж суурилуулсан нь холбооны найдвартай ажиллагаа, чанар байдлыг дээшлүүлсэн байна.

Аймгийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга Б.Азжаргал “Хөдөлгөөнт удирдлагын байр”-тай 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр танилцан, Онцгой байдлын байдлын газарт хүлээлгэн өгөх ёслолын ажиллагааг зохион байгуулан үйл

ажиллагааг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлан ажиллалаа.

Аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний 4 дүгээр бүлэг гамшгийн үеийн хариу арга хэмжээ буюу Газар хөдлөлт, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ, зарлан мэдээлэл хэсэгт тодотгол хийсэн.

Орон нутгийн 2 фм, радиогоор цахилгаан хэрэгслийн галын аюулаас урьдчилан сэргийлэх шторкийг өдрийн 3 удаагийн давтамжтай 20 хоногийн хугацаанд давхардсан тоогоор нийт **120** удаа нэвтрүүлээд байна.

Цахилгаан хэрэгслийн галын аюулгүй байдал, Бага насны хүүхдийг ахуйн ослоос урьдчилан сэргийлэх цахим хичээлийг өдрийн 4 удаагийн давтамжтайгаар 25 хоног 400 удаа нэвтрүүлсэн. Орон нутгийн DBS, RGB телевизээр гэр байшингийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх шторкийг өдрийн 4 удаагийн давтамжтай давхардсан тоогоор 50 удаа, цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ сэрэмжлүүлгийг тус тус нэвтрүүлж иргэд олон нийтэд хүргэж байна. Цаг үеийн холбогдолтой 128 мэдээлэл боловсруулан Онцгой байдлын ерөнхий газар, Онцгой байдлын газар, аймаг, сумын цахим хаягт тус тус байршуулсан. Пиротехникийн хэрэгслээс урьдчилан сэргийлэх-2, Гал түймрээс урьдчилан сэргийлэх-3, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлаа хангах талаар-1, ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан хулгайн замаар болон голын мөсөн дээгүүр зорчихгүй байх талаар-1, орон нутгийн 3 телевизийн шууд ярилцлагад-2 удаа, МҮОНРТ-ийн “Өглөө” хөтөлбөрийн онлайн нэвтрүүлэгт оролцож Дархан-Уул аймгийн ковид-19 цар тахлын нөхцөл байдлын мэдээлэл өгсөн, нийт 10 удаагийн мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд хүргэсэн.

Орон нутгийн Гэр бүлийн радио FM-104.5-ын Онцгой байдлын цаг нэвтрүүлэгт 7 хоног бүрийн Лхагва гарагт оролцож Пиротехникийн хэрэгслийн осол, Объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх, Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах талаар мэдээлэл хийсэн.

Цаг үеийн холбогдолтой 52 мэдээлэл боловсруулан Онцгой байдлын ерөнхий газар, Онцгой байдлын газар, аймаг, сумын цахим хаягт тус тус байршуулсан.

Дархан-Уул аймгаас иргэдийн гарах орох хөдөлгөөнийг хянах, зохицуулах үүрэг бүхий Ажлын хэсэгт томилогдон Дархан-Уул аймгаас Улаанбаатар хот бусад аймаг руу иргэдийг бүртгэлжүүлэн гаргах ажлыг зохион байгуулж мэдээг тухай бүр Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабт хүргүүлэн ажилласан.

Аймгийн Шуурхай штабаас өгөгдсөн 50 дугаар хурлын тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн хэрэгжилтийг хангах хүрээнд Шуурхай штабын Starex 45-07 дах автомашинтай Хонгор сумын 2 дугаар баг Зулзагын гол орчмын амралт зугаалгын бүсэд амралтын өдрөөр анхааруулга сэрэмжлүүлэг хүргэх зорилгоор 2020 оны 12 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд ажилласан. Гэр бүл найз нөхдөөрөө агаар салхинд гарч уулан дээр хүүхдүүдээ салхилуулж байсан 30 автомашин бүхий 180 гаруй иргэдэд ил задгай гал асаахгүй байх, бага насны хүүхдэд тавих хараа хяналтыг сайжруулах, ковид 19 вирусээс урьдчилан сэргийлж хүний төвлөрөл үүсгэхгүй байх, ил задгай хог хаягдал хаяхгүй байх талаар сэрэмжлүүлэг сурталчилгаа хийж ажилласан.

Энэ сард Гал түймэр унтраах, аврах ангиуд 13 удаагийн гал түймрийн дуудлага хүлээн авснаас байлдааны тархалт хийж унтраасан-10 иргэд унтраасан-3 дуудлагатай байлаа. Гал түймэр унтраах, аврах ангиуд 10 удаагийн гал түймрийн дуудлага дээр тактикийн алдаа дутагдалгүй ажиллаж гал түймрийг унтрааж, ААНБайгууллага иргэдэд учирч болзошгүй 191 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

Улсын хяналтын байцаагч энэ сард эрх зүйн баримт бичгийг 56 удаа үйлдсэн байна. Хяналт шалгалтанд нийт 12 байгууллага, объект хамрагдаж Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, норм стандарт, дүрэм журам зөрчсөн 10 зөрчлийг илрүүлж, 6 зөрчлийг арилгуулж, төсөв хөрөнгө, цаг хугацаа шаардсан бусад зөрчлийг арилгуулхаар Заавал биелүүлэх албан шаардлага-4, мэдэгдэл-45, танилцуулга 2 бичиж, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар заавар зөвлөгөө өгч ажилласан.

Аймгийн Онцгой комиссын 2021 оны 01, 02, 03 дугаар хурлын бэлтгэл ажлыг хангуулан засаг даргын шийдвэрээр хуралдуулж гарсан шийдвэрүүдийг гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сумдын Онцгой комисс, ААНБ-д хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Шуурхай штабд ирсэн 29 өргөдөл, 31 албан тоотыг Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргад танилцуулж гарсан шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ангиллын сургалтаар Аюулт үзэгдэл техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх мэдлэг боловсрол олгох, объектын галын аюулгүй байдлыг хангах, гал түймрийн тоо, хохирол, эрсдэлийг бууруулахад ААНБ-ын ажилчдын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Минж проперти байгууллагын ажилтан албан хаагчдад цахимаар судлах хичээлийн презентэйшн өгч цахим сургалтыг зохион байгуулсан. Энэ хүрээнд тус компанийн 16 ажилтан хамрагдаж мэдээлэл авсан.

Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн ажиллах журам шинэчлэн боловсруулах Ажлын хэсэгт орж шинэчилсэн бүрэлдэхүүн томилуулах, гүйцэтгэх ажлын журмыг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

ОБЕГ-ын даргын баталсан 2016 оны А/76 тоот зааврын дагуу “Анто-Од” ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн Химийн ослын төлөвлөгөөг хянаж Онцгой байдлын газрын даргаар баталгаажуулсан.

Газрын даргын 12 тушаал гарсныг төрлөөр нь ангилбал: Алба хаагчтай холбоотой 5, үйл ажиллагаатай холбоотой 7 тушаал гарч хэрэгжилтийг хангуулан үр дүнг тооцон ажиллаж байна.

Онцгой байдлын ерөнхий газар болон аймаг орон нутаг, бусад байгууллагаас нийт 65 албан бичиг ирснээс 54 албан бичгийн хариуг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хүргүүлж, 8 албан бичгийн хугацаа болоогүй, 3 албан бичгийг танилцуулан мөн 11 өргөдөл гомдлыг хүлээн авч 5 өргөдлийн хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн 6 өргөдлийн хугацаа болоогүй байна.

Аймгийн Онцгой комиссын Шуурхай штаб нь гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сумдын Онцгой комиссыг шуурхай удирдлага зохион байгуулалтаар ханган, салбар дундын хамтын ажиллагааг идэвхижүүлэн ажиллаж байна.

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 1650 өргөдөл гомдол, санал удаагийн хүсэлтийг улсын хяналтын байцаагч нар шалгаж шийдвэрлэсэн байна.

3. Хууль эрх зүйн чиглэлээр:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгдчийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолын төсөл, Засаг даргын захирамжийн төсөл, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалын төслийн үндэслэлийг тус тус хянаж зөвлөгөө өгч, Захирамж, тушаалд ашиг сонирхлын зөрчилгүй мэдүүлэг гаргах шаардлагатай эсэхийг шийдвэрлэн ажиллаж байна.

“Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг гаргаж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэж АТГ-т, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн ажлын албанд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2020 оны төлөвлөгөөний биелэлтийг тус тус гаргаж хүргүүллээ.

5 албан тушаалтны ХАСХОМ –ийг хянаж хүлээн авч, ЭБАТ-д “ХАСХОМ-ийн мэдээ тайланг хэрхэн гаргах” талаар сургалт зохион байгуулан, ХАСХОМ 2020 онд их хэмжээний өөрчлөлт, шинэчилэн гаргасаныг хүлээн авч баталгаажууллаа.

Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 183/Ш3202/00255 дугаар захирамжийн дагуу холбогдох нотлох баримтуудыг гаргаж хүргүүллээ.

Хуулийн цаг нэвтрүүлгийн 2021 оны 2 удаагийн дугаарыг хийж, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, Хүний нэр төр, алдар хүндэд халдахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл хийлээ.

“Дайчилгааны зарлан мэдээлэл явуулах журам”-ын төсөлд нөлөөллийн шинжилгээ хийх талаар Захиргааны ерөнхий хуулийн холбогдох заалтууд, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/147 дугаар тушаалаар баталсан “Нөлөөллийн шинжилгээ хийх аргачлалын талаар зөвлөгөө өгч, хамтран ажиллаж, аймгийн Тагнуулын газраас ирсэн судалгааг гаргаж хүргүүллээ.

Эрх зүйн цахим хөтөч сайтад байрлуулдаг мэдээллийг шинэчлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, алба, сумд зэрэг нийт 29 байгууллагад албан бичиг хүргүүлэн, ирүүлсэн мэдээллийг нэгтгэн ажиллаж байна.

Архивын тасгаар давхардсан тоогоор 93 иргэний хүсэлтийг хүлээн авч, архивын уншлагын танхим болон лавлагаа мэдээлэлд 630 хадгаламжийн нэгжээр үйлчилж, архивын хуулбар, цалингийн тодорхойлолт, албан бичгээр нийт 126 лавлагаа олгож, орон нутгийн төсөвт 170.000 төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүллээ.

Цахим санд: Байнга хадгалах 3 хөмрөгийн 22 хадгаламжийн нэжийн 3727 хуудасны 33739 заалтанд тодорхойлон бичилт хийж цахим санд орууллаа. Нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөөний дагуу Политехник коллежийн 1985-1991 оны 10 хн–ийн 1816 хуудасны 16447 заалтад тодорхойлон бичилт хийлээ.

Төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын 2019 оны архивын баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээний талаарх мэдээг хөмрөг үүсгэгч 104 байгууллагаас гаргуулан авч нэгтгэлээ.

Онцгой байдлын газрын 36 албан хаагчидад “Баримт бичиг зохион бүрдүүлэхэд тавигдах шаардага, баримт бичгийн боловсруулалт” сэдэвт сургалт зохион байгууллаа.

Силикат тоосго шохойн үйлдвэр, Карьерын нэгдсэн аж ахуй, Барилга үйлдвэрлэлийн нэгдэл, Цементийн завод зэрэг 4 хөмрөгийн цалингийн баримтанд нягтлан шалгалт хийж бүртгэлийг шинэчиллээ.

Шинээр ашиглалтанд орсон барилга байгууламжийг хүлээн авах улсын комиссын 2 хуралд оролцож 5 хадгаламжийн нэгж хүлээн авлаа.

Архивын тасгийн дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг бэлтгэлээ.

4. Төсвийн санхүү, татвар, санхүүгийн хяналтын талаар:

Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагын төсвийн гүйцэтгэлийн 2020 оны 12 дугаар сарын мэдээг боловсруулж, нэгтгэн Сангийн яам, аймгийн цахим хаяг <http://darkhan.gov.mn>, АЗДТГ-ын төсөв санхүүгийн ил тод байдлын самбарт тус тус байршуулж, төсвийн ил тод байдлыг хангаж ажилласан.

2020 оны 12-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 30,231.3 сая төгрөг төвлөрөхөөс 32,441.9 сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 107.3 хувь буюу 2,210.6 сая төгрөгөөр давж биелэсэн байна.

Мэдээгээр зарлага санхүүжилтийн хувьд орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн байгууллага, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарлага санхүүжилтэнд 78,232.0 сая төгрөг зарцуулахаас 73,312.4 сая төгрөг зарцуулжээ.

Мөн аймгийн хэмжээнд 12 дугаар сарын байдлаар 2,217.2 сая төгрөгийн авлагатай, 561.7 сая төгрөгийн өглөгтэй гарсан бөгөөд өр төлбөрийн 1.7 хувийг цалин, НДШ, 12.1 хувийг тогтмол зардал, 86.2 хувийг бараа үйлчилгээний бусад зардал эзэлж байна.

2021 онд ЗГУМСистемд ашиглагдах дансдын судалгааг гарган Сангийн яаманд хүргэсэн ба 2021 оны 01 дүгээр сарын төсвийн зарцуулалтын эрх нээгдэн төсвийн байгууллагуудын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Төсвийн байгууллагууд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа гарган аудитын байгууллагаар аудит хийлгүүлж байна.

ААН-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авах талаар олон нийтэд мэдээлэл хүргэн тайланг татварын тайлантай тулган хүлээн авч байгаа бөгөөд тайлангийн ирц 20 хувьтай байна.

2021 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн байдлаар татварын орлогоор орон нутгийн төсөвт 1,909.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 205.2 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний гүйцэтгэл 10.7 хувь буюу 1,704.3 сая төгрөгөөр, улсын төвлөрсөн төсөвт 705.3 сая төгрөг төвлөрүүлэхээс 435.4 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний гүйцэтгэл 61.7 хувь буюу 569.9 сая төгрөгөөр тус тус тасарсан дүнтэй байна.

Мөн газрын төлбөрийн өмнөх 2020 оны нэхэмжлэхийг үүсгэсэн ба 2021 оны ногдол бүхий нэхэмжлэх, АТБӨЯХАТ, АБ, Замын сангийн хураамжийн ногдолыг Татварын удирдлагын нэгдсэн системд татуулахаар Татварын ерөнхий газарт саналаа хүргүүлсэн. Эхний 1, 6 дугаараар төгссөн АТБАЯХАТ-ын ногдол баазад үүсэж зар сурталчилгааг эхлүүлсэн байна.

Татварын хэлтэс нь “Дуудлагын төв”-ийн 1800-1288 дугаарын утсаар 251 иргэн болон аж ахуйн нэгжид, нэхэмжлэх болон төлбөрийн баримтаар 50, татан буугдах хуулийн этгээдэд зөвлөгөөг 12, хуулийн этгээдийн нэмэлт өөрчлөлтийг 2 ААН-д, үл хөдлөх хөрөнгө борлуулсан иргэдэд төлбөрийн даалгавар 37, газрын эрх шилжүүлсэн иргэдэд урьдчилгаа нэхэмжлэх үүсгэж өгсөн 3, нэвтрэлтийн нэгдсэн системд нэвтрэх заавар 59, ХХОАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх хүсэлтэй 156, Ebarimt нууц код зөвөлгөө 133 иргэнд тус тус үйлчилж ажиллалаа. Мөн ХХОАТ-ын тайлан, татварын хөнгөлөлт, чөлөөлтийн талаар татвар төлөгчдийн асуултад хариулт өгч шууд нэвтрүүлэг зохион байгуулсан.

Татварын хяналт шалгалтаар урьд оны болон тайлант оны татварын хяналт шалгалтанд хамрагдсан татвар төлөгчийн өрийн судалгааг байцаагч бүрээр гаргаж өрийг барагдуулан ажиллаж байна. Үүнээс урьд оны 1 ААН-ийн 3250.8 мянган төгрөг, тайлант оны 1 ААН-ийн 2478.9 мянган төгрөгийн өрийг тус тус барагдуулан ажиллалаа.

2020 оны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Орон нутгийн өмчийн газар, 6-р цэцэрлэг, Хонгор сумын ЗДТГазар, нөөц сан, Хонгор сумын Орон нутаг хөгжүүлэх сан, Дархан Дулааны сүлжээ ТӨХК, Орхон сумын Орон нутаг хөгжүүлэх сан, Сум хөгжүүлэх сан, Шарын гол сумын ЗДТГазар, нөөц сан, Шарын гол сумын Орон нутаг хөгжүүлэх сан, Соёлын төв, 6-р сургууль, БСУГазрын үйл ажиллагааны санхүүгийн баримтанд хяналт шалгалтын ажлыг хийж байна. 2017-2020 оны санхүүгийн үйл ажиллагааны баримтын шалгалтыг дараахи газарт хийж дуусгасан ба НДХэлтэст 0,1 сая төгрөгийн, 3 дугаар цэцэрлэгт 0,4 сая төгрөгийн зөрчилд Улсын ахлах байцаагчийн акт тус тус тогтоож ажиллажээ.

Дархан-Уул аймгийн Мэдээлэл технологийн албаны 2019-2020 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагааны баримтанд дотоод аудитыг хийж тодруулга авч дуусгасан ба шалгалтаар илэрсэн зөрчилд зөрчлийг арилгуулах тухай 2 зөвлөмж өгч ажилласан байна.

Захиргааны ерөнхий хуулийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтын явцад холбогдох ажилтан, мэргэжилтнүүдтэй уулзан “Сонсох ажиллагаа”-г зохион байгуулж ажилласан байна.

Актын төлбөрийн үлдэгдэлтэй байгууллагуудын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт актын төлбөрийн үлдэгдлийг барагдуулахыг анхааруулжээ.

5. Нийгмийн бодлого

БСУГ-аас “Шилдэг илтгэл” II уралдааныг 2021 оны 01 дүгээр сарын 08-ний өдөр Од цогцолбор сургуулийн урлаг зааланд зохион байгууллаа. Нэг дэх уралдаанд 30 багшийн илтгэл ирсэн бол хоёр дахь шатанд 15 илтгэл шалгарч аваргаа шалгаруулж байна. 2021 оны 01 дүгээр сарын 06-07-ны өдрүүдэд Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын захирал, эрхлэгч нарын зөвлөгөөн

уулзалт боллоо. Зөвлөгөөнд 2021 онд хийж хэрэгжүүлэх үндсэн зорилтууд Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилго зорилтуудыг хэрхэн хийж хэрэгжүүлэх талаар хэлэлцлээ.

Аймгийн онцгой комиссын шийдвэрээр зарим спорт заал, түр сургалтын төвүүдийг нээж ажиллуулах шийдвэр гарсантай холбогдуулаад спорт заалтай сургуулиудад мэргэжилийн хяналтын газраас ирүүлсэн зөвлөмж, асуумжийн хүснэгтийг хүргүүлж ажиллаж байна. Түр сургалтын төвүүдийн шалгалтыг БСУГ-ын даргын шийдвэрээр Соёл урлагийн ажилчдыг дайчлан ажилласан. Мөн ЭЕШ-д орох 12 дугаар ангийн хүүхдүүдтэй сургуулиуд танхимаар давтлага өгөх болсон. Энэ жил ЕБС-ийн 1249 сурагч ЭЕШ өгөх юм. Танхимын давтлага өгөх болсонтой холбогдуулан БСУГ-аас онцгой нөхцөл байдлын зөвлөмжүүдийг сургуулийн удирдлагуудад хүргүүлж эрүүл ахуйн шаардлагын дагуу анги танхимаа бэлгэж ажиллаж байна. 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр сурагчдын ирц 89% байна. Үйл ажиллагаа явуулж буй түр сургалт, үсчин, гоо сайхан, саун, халуун ус, иог, фитнесс, спорт заал зэрэг 130 гаруй байгууллагын халдвар хамгааллын дэглэм, мөн 18 хүртэлх насны хүүхдүүд нийгмийн харилцаанд орж буй байдалд Дархан-Уул аймгийн их дээд мэргэжлийн сургууль, соёл урлаг, ЕБС, СӨБ зэрэг 58 байгууллагын 100 гаруй багш, ажилтан ажиллагсад хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн боловсролын салбарын хөгжлийн стратегийг боловсруулах хэлэлцүүлэг боллоо. Хэлэлцүүлэгт оролцогсод СӨБ, ЕБС-иудын хөгжлийн төлөв байдал, сургалтын үйл ажиллагаа, багшийн хөгжлийн талаар харилцан ярилцаж, санал солилцов. 2021 оны 1 дүгээр улиралд багтаан бодлогын баримт бичгийг боловсруулах үйл ажиллагаа хийгдэхээр төлөвлөгдөж байна.

Аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу үйл ажиллагаа явуулж буй түр сургалт, үсчин, гоо сайхан, саун, халуун ус, иог, фитнесс, спорт заал зэрэг 130 гаруй байгууллагын халдвар хамгааллын дэглэм, мөн 18 хүртэлх насны хүүхдүүд нийгмийн харилцаанд орж эхэлсэнтэй холбогдуулан Дархан-Уул аймгийн их дээд мэргэжлийн сургууль, соёл урлаг, ЕБС, СӨБ зэрэг 58 байгууллагын 100 гаруй багш, ажилтан ажиллагсад хяналт тавин ажиллаж байна. 2021 оны 01 дүгээр сарын 18-22-ны өдрүүдэд 422 байгууллагад 270 алба хаагч хяналт тавьж өдөр бүрийн мэдээг БСУГ нэгтгэн Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлж байна.

Галын аюулаас шалтгаалан орон гэргүй болсон ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн Англи хэлний багш Б.Даваацэцэгийн гэр бүлд туслах “Халуун сэтгэл” хандивын аяныг БСУГ, Монголын багш нарын холбооны Дархан салбараас зохион байгуулж 2021 оны 01 дүгээр сарын 22-ний өдөр цугласан хандивыг гардуулан өглөө. ЕБС, СӨББ-ын 2020 оны 12 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг нэгтгэж, 2020 онд өр авлагагүй байна. Биеийн тамир спортын улсын хорооноос бүх аймгуудын мэдээлэлийн цахим сан бүрдүүлэх онлайн сургалтанд 3-н албан хаагчид хамрагдаж, цахим сан бүрдүүлэх ажлыг эхлүүлээд байна.

Эрүүл мэндийн газар шуурхай штабын 24 цагийн хариуцлагатай жижүүрүүд хуваарийн дагуу хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, нэгдсэн эмнэлэг, өрх, 3 сумын эрүүл мэндийн төвүүдээс ковидын үед авч хэрэгжүүлж байгаа ажил, үйлчилгээ тусгаарлах үйл ажиллагаа, ковидын шинжилгээ зэрэг цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээлийг авч нэгтгэн холбогдох газруудад 2 цаг тутам мэдээллэж ажиллаж байна. Мөн шуурхай штабын утсанд ирсэн дуудлага бүрт хариу өгч, ажилласан байна.

Аймгийн Онцгой байдлын штаб дээр НЭМТ-ийн хавдрын дүн бүртгэгч Я.Отгонзаяа ажиллаж 310 тохиолдолд зөвшөөрөл олгосон байна. УБ хотоос ирсэн

гэрийн ажиглалтанд хянах давтан шинжилгээ авах оюутнуудын нэрсийг өрхийн эмнэлэгийн цахим сүлжээ хаяг руу илгээсэн.

Сэжигтэй тохиолдлыг Улаанбаатар хот тээвэрлэх, тусгаарлалтад ажиллах эмч, сувилагчийг Гранд-ЯК зочид буудалд оруулах, ойрын хавьтлыг тусгаарлах бэлэн байдлыг хангуулан ажилласан. Батлагдсан тохиолдлыг халдварт өвчин судлалын үндэсний төв рүү хүргэж ажиллалаа.

Тусгаарлалтанд ажиллаж байгаа эмч, сувилагчтай холбогдож мэдээ мэдээлэл авч, халдвар хамгааллын дэглэмээ сахиж, аюулгүй ажиллах зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллалаа.

Монгол даатгалын газартай гэрээ байгуулан ажилчдыг гэнэтийн ослын болон хөдөлмөрийн чадвар алдалтын даатгалд хамруулах ажлыг зохион байгууллаа.

Нийт 19 тасагт 9 ариутгагч ээлжит ариутгал халдваргүйжүүлэлтээ хийсэн. Нийт талбай 1950кв талбайд хийгдсэн байна. Улаанбаатар хотоос ирсэн 259 иргэний гэрийн 1200 мкв талбайд ариутгал, халдваргүйжүүлэлт хийсэн.

Дархан суманд Ковидын батлагдсан тохиолдол гарсантай холбогдуулан ажиглан тусгаарлах байрны бэлтгэл бэлэн байдлыг хангуулан ажиллаж 2021.01.29 ны өдрийн байдлаар 81 иргэнийг тусгаарлалтанд байна. Тусгаарлах үйл ажиллагаанд 1 их эмч, 1 сувилагч ажиллаж байна.

Улаанбаатар хотод өргөө амаржих газарт гарсан алдаатай холбогдуулан төрөх тасаг болон Нэгдсэн эмнэлгийн тасгуудын өвчтөн шилжүүлэх эх барих эмэгтэйчүүдийн тасгийн нүүлгэн шилжүүлэлтийн бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Халдвартын тасагт шинжилгээ өгөх иргэдэд дараалал үүсэх хүлээгдэлтэй холбоотой бөөгнөрөл үүсэж байгаа нөхцөл шалтгааныг судлан харуул хамгаалалтын алба болон цагдааг газартай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улаанбаатар хотоос ирсэн болон гэрийн ажиглан тусгаарлах ажиглалтанд байгаа иргэдийн хяналтыг сайжруулах зориолгоор салбар дундын хамтын ажиллааг сайжруулах зорилгоор гар утасны аппликейшн суулгалт, хяналтыг сайжруулах зориолгоор цагдаагийн газар, онцгой байдлын газар, аймгийн Засаг даргын Тамгын газар, Дархан сумтай хамтарсан уулзалт хийх ажлыг санаачлан хийх бэлтгэл ажлыг хангаж байна.

Эрүүл мэндийн яам, халдварт өвчин судлалын үндэсний төвөөс хамтран зохион байгуулсан халдвараас хамгаалах хувцас өмсөх тайлах халдваргүйжүүлэх сургалтанд 10 байгууллагын 89 эмч эмнэлгийн ажилтан, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын лабораторийн ажилтнуудад халдвар хамгаалал, шинжилгээ авах арга, аргачлалаар сургалт, Сэтгэцийн Эрүүл мэндийн үндэсний төвөөс сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн бүх ажилчдад сэтгэл зүйн, геронтологийн үндэсний төвөөс ахмадын настны эрүүл мэндийг дэмжих, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгамдаж буй асуудал, ковидын үеийн тушаал, шийдвэр, халдварын сэргийлэлт хяналт, хувийн хамгаалах хувцас хэрэгслийг зөв өмсөх, аюулгүй тайлах зэрэг сэдвээр цахим сургалт зохион байгуулагдаж байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эмэгтэйчүүдийн 6 үүдэн эмнэлгийн эмч нартай болон Саран-энх эмэгтэйчүүдийн ортой эмнэлгийн хамт олонтой коронавирусын халдварын үед хамтарч ажиллах гэрээгээр бичгээр хийсэн. 2021.01.31 нд Аймгийн Засаг даргын захирамжаар орон нутгийн нөөц сангаас 3 сумын эрүүл мэндийн төвд тус бүр 3 сая нийт 9 сая төгрөгний

өртөг бүхий 1 удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын бодис, уусмал, вирусны эсрэг эм хэрэгслийг эрүүл мэндийн төвийн дарга нарт хүлээлгэн өглөө.

ГБХЗХГ-ын Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн бэлэн байдалд ажиллаж, цаг үеийн мэдээ мэдээллийг өдөр бүрийн "Хүн ам нийгмийн хамгааллын шуурхай штаб", агентлагт тайлагнан ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр 01 дүгээр сарын 7-ноос эхлэн 16 төрлийн 336 үйл ажиллагааг нээж хэвийн горимоор ажиллуулахаар болсонтой холбогдуулан тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдыг түргэвчилсэн шинжилгээнд хамруулах ажлын бүртгэл судалгааны хэсэгт хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн гишүүд ажиллаж 400 гаруй хүнээс шинжилгээ авах ажлыг зохион байгууллаа.

Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн 7 гишүүн Дархан-Уул аймгийн Онцгой комиссын чиглэлийн дагуу Дархан-Уул аймгаас Улаанбаатар хот, бусад орон нутаг руу явах 923 иргэний бүртгэл хийж Авто тээврийн төвд 2 удаа ажиллалаа.

Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн гишүүд эрсдэлийн программд бүртгэгдсэн 68 өрхтэй холбогдож ажиллахаас 16 өрхтэй холбогдож, эргэн хяналт тавихад 2 өрх хоол хүнсний дэмжлэг шаардлагатай, сургууль завсардсан 1 хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 1 хүүхдийг илрүүлж холбогдох байгууллагад мэдээлж холбон зуучилж, хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэн ажиллалаа. Нийт 1339 хүн

Шүүхийн захирамжийн дагуу хүүхдийн асрамж тогтоох иргэний 7 хэрэгт Шинжээчийн багаар ажиллаж 5 өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийж, психометрек шинжилгээ авч, Улаанбаатар хотын Налайх, Баянзүрх, Орхон аймгийн ГБХЗХГ-тай хамтран ажиллаж байна.

ХБХЭМБНХСКомиссын хурлаар хөгжлийн бэрхшээлтэй 21 хүүхдийн асуудлыг шийдвэрлэлээ.

Шарын гол сумын эрсдэлийн программд бүртгэгдсэн 8 өрхийн 15 хүүхдийн нөхцөл байдалд эргэн хяналт тавиж, ГБХЗХГ, Сумын эмэгтэйчүүдийн холбооноос хүнс, халдваргүйтжүүлэх хэрэгсэл, дархлаа дэмжих бүтээгдэхүүнээр хангалаа.

ХЭХЗХ-ны хяналтад нийт 24 хүүхэд бүртгэлтэйгээс хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 19 өсвөр насны хүнтэй утсаар холбогдож зөвлөмж өгч, гэмт хэрэг, зөрчилд гэрч, хохирогчоор тооцогдсон 5 хүүхдэд хууль ёсны төлөөлөгчөөр томилогдон ажиллаж, хохирогч 1 хүүхдийн шүүх хуралдаанд оролцож, хохирогч 1 хүүхдийн эрх ашгийг хамгаалж яллагдагчаас 2764.000 төгрөгийн нөхөн төлбөр гаргуулахаар шийдвэрлэв.

Сэтгэл зүйн үйлчилгээг 12 хүнд үзүүлж, үрчлэлтийн асуудлаар 3 өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийж Дархан сум, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ЗДТГ-т хүргүүллээ.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд гэр бүлийн орчны үл хайхрах хүчирхийллийн дуудлага 7, сэтгэл санааны хүчирхийлэл 4, бие махбодын хүчирхийлэл 2, сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын дуудлага 2, хоол хүнсний тусламж дэмжлэг шаардлагатай 1, нийт 16 дуудлага хүлээн авч, хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж шийдвэрлэлээ. Нийт 116 хүн

Түр хамгаалах байранд 2 насанд хүрэгч 2 хүүхдийг хүлээн авч, насанд хүрэгчдийг PCR-ын түргэвчилсэн шинжилгээнд хамруулж, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, эрүүл мэнд, сэтгэл зүй, хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж, 1 насанд хүрэгч 1

хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх ажлыг зохион байгуулж хамтарсан багт зөвлөмж чиглэл өгч, 1 насанд хүрэгчийг Шүүх эмнэлэгт үзүүлж онош тодруулах үе шатандаа явж байна.

2019-2020 онд хамгааллын үйлчилгээ авч гэр бүлдээ эргэн нэгтгэгдсэн 37 насанд хүрэгч, 38 хүүхэдтэй утсаар холбогдон мэдээлэл солилцон тулгамдсан асуудал, дэвшилттэй зүйлүүдийг судлаж бүртгэлжүүлэн ажиллалаа. Нийт 79 хүн

“Залуучуудыг гэртээ дасгал хөдөлгөөнтэй байя” цахим хичээлийг орон нутгийн 2 телевизээр тогтмол цацаж, шинээр “Үндэснийхээ бүжгийг сурч, хөдөлгөөний дутагдалаас сэргийлэн, дархлаагаа дэмжэе” гэр бүлээрээ сурахад уриалсан бүжгийн цахим хичээл зохион байгуулж, 4 гэр бүлийн 8 том хүн, 11 хүүхэд сурсан ба гэр бүлүүд тус бүрдээ 3, 3 гэр бүлийг энэхүү давалгаад урьж оролцуулан үргэлжлэн явагдаж байна.

Залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх бие даан англи хэл суралцах залуусын “ENGLISH CLUB” клубыг нээж сургалтыг цахим болон танхимын хосолсон хэлбэрээр зохион байгуулж одоогоор нийт 25 гишүүн 3 багт хуваагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Аймгийн Үйлдвэрчний эвлэлтэй хамтарсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэшсэн ажилтан бэлтгэх 14 хоногийн төлөвлөгөөт 124 цагийн сургалтад 6 ажилтанг хамрууллаа. Тус 6 ажилтан нь өөрийн харъяа багийн иргэд, аж ахуй нэгж байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгч ажиллах юм.

Өмнөх оны Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмлэгт хамрагдсан 31 төсөл хэрэгжүүлэгчийн гэрээг шинэчлэн байгуулж ХХҮЕГ-т хүргүүлээд байна. Дээрх төсөл хэрэгжүүлэгчид эдийн засгийн хүндрэлтэй өнөөгийн нөхцөлд ажлын байраа хадгалж үлдэх боломжийг бүрдүүлж, санхүүжилтэд хамрагдана. Мөн өмнөх онд Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 5 малчин өрхөд тус бүр 5 шуудай малын тэжээлийг олгосон.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн загвар төвийн болон ажлын туршлага олгох интерншип хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилт 2021 оны ажлын төлөвлөлт сэдвээр Швейцарийн хөгжлийн агентлагийн төсөл хэрэгжүүлэгч багтай 2 удаа онлайн хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтын хүрээнд тус загвар төвийг цаашид хэрхэн хөгжүүлэх, дахин хөрөнгө оруулалт хийх замаар үйл ажиллагааг нь өргөжүүлэх тал дээр харилцан санал солилцож зарим тулгамдаад байгаа асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэхээр тохиролцлоо.

Шинээр төрсөн – 134 хүүхдийг бүртгэсэн

Гадаадад оршин суугаа – 4 хүүхдийн мөнгөн тэтгэмжийг итгэмжлэлийн дагуу бүртгэсэн.

Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдах 6 иргэний хүсэлтийг хүлээн авч бүртгэсэн.

Шүүх, сургалтын төлбөр зэрэг шалтгаанаар Өрхийн амьжиргааны түвшний тодорхойлолт – 19 иргэнд гаргаж үйлчилсэн.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлэх хүнсний дэлгүүр, аж ахуй нэгжийг сонгон шалгаруулах ажил 2 дугаар сард зохион байгуулагдах бөгөөд тус ажлыг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулж анхдугаар хуралдааныг зохион байгуулж, тендерийн материалыг цахим хэлбэрээр байршуулаад байна.

Тус сард нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, тусламж хөнгөлөлтөд 10,631 иргэнийг хамруулж улсын төсвийн 1,121,529,680 төгрөгийн санхүүжилтийг олголоо.

Цахим хэлбэрээр:

- 4 хүртэл насны ихэр хүүхдэд олгох тэтгэмжид 3 иргэнийг хамруулж 6,0 сая төгрөг
- Жирэмсэн эхийн тэтгэмжид 840 иргэнийг хамруулж 32,462,063 төгрөг
- 0-3 хүртэл насны хүүхэд асарсны тэтгэмж /цалинтай ээж/-д 5088 эхийг хамруулж 250,517,641 төгрөг
- Өрх толгойлсон 3 ба түүнээс дээш хүүхэдтэй эцэг, эхэд олгох тэтгэмжид 11 иргэнийг хамруулж 4,346,087 төгрөг

Арилжааны банкаар дамжуулан:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр – 1790 иргэн – 509,256,570
- Нийгмийн халамжийн тэтгэмж – 1842 иргэн – 165,608,010
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргааны мөнгөн тэтгэмж – 348 иргэн – 98,771,600
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргааны мөнгөн тэтгэмж – 54 иргэн – 3,240,000
- Ахмад настны асаргааны мөнгөн тэтгэмж – 220 иргэн – 13,200,000
- Ахмад настны хөнгөлөлт, тусламж – 111 иргэн – 24,423,500
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж – 324 иргэн – 13,734,600 төгрөгийн санхүүжилтийг тус тус олгоод байна.

1. Үйлчилгээний тасгийн ажлын талаар

- Шинэ тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчдын тоо

Тэтгэвэрийн төрөл	7 хоногийн дүн	Өссөн дүнгээр
Өндөр насны тэтгэвэр	15	80
Тахир дутуугийн тэтгэвэр	10	24
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	1	6
Малчин өндөр насны тэтгэвэр тогтоолгосон	3	8

Тэтгэвэр авагчдын шилжилт хөдөлгөөн

Хөдөлгөөний төрөл	7 хоногийн дүн	Өссөн дүнгээр
Шилжиж ирсэн	1	3
Шилжиж явсан	2	4
Нас барсан	4	22

Хоёр. Тэтгэмжийн даатгалын сангаас олгосон тэтгэмжийн чиглэлээр:

Тэтгэмжийн төрөл	7 хоногийн дүн	Өссөн дүнгээр
-------------------------	-----------------------	----------------------

	Хүний тоо	Дүн /сая төгрөгөөр/	Хүний тоо	Дүн /сая төгрөгөөр/
Хөдөлмөрийн чадвар түр алдсан тэтгэмж	99	15.7	267	47.0
Жирэмсэн амаржсан тэтгэмж	35	57.7	150	232.7
Ажилгүйдлын тэтгэмж	41	22.0	239	122.7
Оршуулгын тэтгэмж	11	11.0	33.0	33.0

Гурав. Аяааа! ае-еа буюуа оооооооооооо! оаааааа:

Албан бичгийн төрөл	7 хоногийн дүнгээр	Өссөн дүнгээр
Ирсэн бичиг	30	78
Явсан бичиг	8	29
Өргөдөл гомдол	7	18

Шийдвэрлэсэн байдал:

Төрөл	Ирсэн бичиг	Өргөдөл гомдол
Хугацаа болоогүй хяналтад	56	18
Хянаж шийдвэрлэсэн	12	
Хугацаа хэтэрсэн		

Дөрөв. Архив хэрэг хөтлөлтийн талаар:

Төрөл	7 хоногийн дүн	Өссөн дүнгээр
Архивын лавлагаа олгосон тоо	50	216
Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцсон батламж олгосон тоо	2	2

Тав. Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын чиглэлээр:

Шинэ тогтоолт	19
Сунгалт хийсэн	62
Буцаасан	1

Цуцалсан	4
Хөдөлмөрийн нөхцөл шинээр тогтоосон	

6. СУМД

6.1. Дархан

Сумын ЗДТГ, 18 багийн хэмжээнд төрийн үйлчилгээг давхардсан тоогоор 7108 иргэнд үзүүллээ.

Дархан сумын иргэдийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах 7037-1313 нээлттэй утсанд нийт 811 дуудлага ирснийг шийдвэрлэн холбогдох байгууллагад шилжүүлэн ажиллаж байна. Үүнд сумдууд болон Улаанбаатар бусад орон нутагт зорчих хөдөлгөөн, Дархан суманд ирэх хөдөлгөөнтэй холбоотой асуудлууд давамгайл байна.

Дархан суманд 100 болон түүнээс дээш настай 6 иргэн, 97-оос дээш насны 14 иргэн байна. Харьяалалгүй 7119 ахмад настны судалгааг аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газарт хүргүүлэв.

ИТХ-ын ажлын хэсэг 1-16, Өргөө, Малчин багийн 2020 оны Хамтарсан багийн үйл ажиллагаатай танилцаж, 2021 оны ажлын төлөвлөгөөг батлууллаа.

2021 оны Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулж байна.

Дархан сумын “Хэвлэл мэдээллийн алба” нь орон нутгийн 2 телевиз /DBS, RGB/, аймгийн Мэдээлэл технологийн алба, Эхлэл 98.9 радиотой хамтран 1 дүгээр сард фото мэдээ, дүрстэй мэдээ, шторк, постер шууд дамжуулалт зэрэг нийт 431 төрлийн мэдээллийг олон нийтэд түгээж ажиллаж байна.

Тайлант хугацаанд ирсэн бичиг 109 үүнээс хугацаатай бичиг 19, хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн 7, хугацаа нь болоогүй шийдвэрлэх шатандаа явж байгаа 12 үүнээс Элчин сайдын яамдуудад визэнд орох 6 иргэнийг уламжиллаа.

Ирсэн өргөдөл гомдол иргэд 57 үүнээс шийдвэрлэж хариу өгсөн 19, шийдвэрлэх шатандаа явж байгаа 04, 02-р дугаар сарын 4 өдөр хүртэл хойшлуулсан 32 Албан хаагч нарын өргөдөл 17 шийдвэрлэсэн 17 байна.

Сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг нь тус сумын 1-16, Өргөө, Малчин багуудын тулгамдсан асуудал, санал хүсэлтийг авч, ажлын тайлан мэдээтэй танилцаж ажиллалаа.

Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөл болон хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг шинэчлэн байгуулах хүсэлтийг сумын ИТХ-д хүргүүлэв.

Тус сумын Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрнгө оруулалт, сум хөгжүүлэх сангийн жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэхээр холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

Тус сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сумын ЗДТГ болон аймгийн ОБГ-т авто машины авах тендерийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр хурьцуулалтын аргаар зарлалаа.

Аймгийн ХХААГ-т тус сумын нутаг дэвсгэрт бэлтгэж хадгалсан болон нөөцөлсөн махны судалгааг иргэн, аж ахуйн нэгжээс авч, хүргүүлэв.

COVID-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын хүрээнд тус суманд үйл ажиллагаа явуулдаг 12 дугуй завсар, 17 автомашины сэлбэгийн дэлгүүр, нэг цэгийн үйлчилгээ 1, олон улсын 2 байгууллага, нийт 32 объектд хяналт тавьж коронавирусээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна.

Дархан суманд 2021.01.01-ний өдрөөс 2021.01.29-ний өдөр хүртэл нийт 1907 иргэн 783 автомашинаар ирсэн байна. Үүнээс Улаанбаатар хотоос 965 иргэн /оюутан-119/, бусад орон нутгаас 942 иргэн, нийт 783 автомашинаар /нийтийн тээвэр-15, суудлын автомашин-768/ ирсэн.

Улаанбаатар хотоос 2021.01.18-ны өдрөөс хойш жижиг тэргээр орж ирсэн иргэдийг шинжилгээнд 7 иргэн Хонгор сумын 2 дугаар баг Хүйтний голд, 8 иргэн Улаанбаатар хот буцсан, холбогдож чадаагүй 2 иргэн байна. Эрүүл мэндийн газартай 18 баг, 4 автомашинаар шинжилгээний ажилд хамтран ажиллаж 100% шинжилгээнд хамруулаад байна.

БСУГ-ын 6 дугаар сургуулийн 59 багш Улаанбаатар хотоос 29-ний өдөр хүртэл жижиг тэргээр ирсэн 296 иргэнд утсаар хяналт тавьж ажиллаж байна. Цагдаагийн газар, Дархан сумын Онцгой комисс, БСУГ-тай хамтран түүврээр биечлэн хяналт тавьж ажиллаж байна. Мөн Дархан суманд ирсэн иргэдийн гар утсанд хяналт тавих GPS системийг суулгаж байна.

Дархан сумын Онцгой комиссын гишүүд шалган нэвтрүүлэх 140, 141 дүгээр постод хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэж, аймгийн Онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу иргэдийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Дархан-Уул аймгийн Онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн Шарын гол, Хонгор, Орхон сумд руу нэвтрэх зөвшөөрлийг 7015 иргэнд олгож, өдөр бүр 3 сумд руу нэвтэрсэн иргэдийн мэдээллийг хүргүүлж уялдаа холбоотой ажиллаж байна.

Мал бүхий иргэдийг хотын төвөөс гаргах 2 байршилтай /Төмсний бригадад 116 айлын газар шулуун татвал 6 км, замаараа тооцвол 12 км, Ноёнхонгорын спиртийн үйлдвэрийн урд 33 айлын газар байгаа төвөөс 8 км/ 2021 оны 01 сарын 16-ны өдөр газар дээр нь очиж танилцлаа.

Мал, тэжээвэр амьтдыг хотын төвөөс гаргах ажлыг 2021 оны 05 дугаар сарын 01-ээс эхлүүлэхээр төлөвлөн аймгийн Захирагчийн ажлын алба, Цагдаагийн газар, ГХБХБГазар, ХХҮГазар, МЭГазар, МХГазар, НААҮГазруудтай хамтран ажиллаж байна.

Ажлын хэсэг 2 удаа хуралдаж мал гаргах, хотын ногоон байгууламж хамгаалах журмын төсөлд чиглэл чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг судалж хамтран ажиллаж байна.

Тус ажлын хүрээнд бэлтгэл ажлыг хангах ажлын төлөвлөгөөг дээрх байгууллагуудад хүргүүлж холбогдох ажлуудыг хугацаанд нь хэрэгжүүлэхийг үүрэг болголоо.

Гэр хорооллын бүсэд байгаа мал, туслах аж ахуйтай өрхийн судалгааг шинэчлэн гаргасан байгаа гэр хорооллын бүсэд 243 өрхийн 7141 толгой мал байна.

Журмын төслийг боловсруулж байгаа бөгөөд хотын ногоон байгууламжид орсон малын эзэнд тооцох хариуцлагын заалтууд дээр аймгийн Шүүх, прокурорын байгууллагаас зөвлөгөө авч ажиллаж байна.

Гэр хорооллын бүсэд байгаа малд Малын тоо толгойн албан татварыг 2000 төгрөг байхаар батлуулж журамд тусгахаар бэлтгэл ханган ажиллаж байна.

Сумын хэмжээнд 2021 оны 01 дүгээр сарын 25-ны байдлаар том малын зүй бусын хорогдлын мэдээгээр өссөн дүнгээр 2 хонь, 3 ямаа хорогдсон мэдээтэй байна.

2020 оны ажлын үзүүлэлтээр МҮОНРТ-ийн нэрэмжит Алтан төлийн эзэнд Малчин багийн малчин Х.Батзоригийг, Улсын тэргүүний фермерт 1 дүгээр багийн иргэн Г.Болор-Отгоныг, Аймгийн аварга малчинд Ц.Нэмэхжаргалыг, Аймгийн сайн малчин тэмдгээр Г.Батцогт, Б.Нямдаваа нарыг шагнуулахаар тодорхойлж холбогдож журмын дагуу материалуудыг бэлтгэн уламжилсан.

2020 оны сүүлийн хагас жилийн арьс, ширний урамшуулалд хамрагдсан 92 малчин, мал бүхий этгээдийн 3037 хонины арьс, 1578 ямааны арьс, 1222 үхрийн шир бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан баримтыг шалган авч Мал хамгаалах сангийн урамшууллын программд шивэлт хийж материалыг архивлан аймгийн ХХААГ-т албан бичгээр хүргүүллээ.

Малын тоо толгой албан татвар тогтоох, татварыг хураан барагдуулах, тайлагнах ажлын төлөвлөгөөг гаргалаа. Төлөвлөгөөг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтэс, Байгаль орчны газарт тус тус хүргүүлж ажиллалаа.

6.2. Орхон

Тус сумын Засаг даргын Тамгын газар нь 01 дүгээр сард иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тайлант сард иргэдээс бичгээр 15 өргөдөл хүлээн авч, 5 өргөдөл шийдвэрлэн, шийдвэрлэх хугацаа болоогүй 10 өргөдөл судлагдаж байна.

Иргэний бүртгэл мэдээллийн үйлчилгээг нийт 112 иргэнд үзүүллээ. **Үүнд:**

- Цахим иргэний үнэмлэх 5 иргэнд
- Гэрлэсний бүртгэл 1
- Шинээр төрсөн хүүхэд 2
- Шинэчилсэн бүртгэл 11
 - Нас барсны бүртгэл 1
 - Шилжин ирсэн 28
 - Овог нэр өөрчилсөний бүртгэл 0

- Эцэг тогтоосны бүртгэл 1

Зөвлөгөө мэдээлэл 63 тус тус байна.

Сумын 2021 оны 1 дүгээр сарын татварын төлөвлөгөө 8000,0 мян,төг гүйцэтгэл 6459,3 мян төг 80,7 хувь байна. Сумын орон нутгийн төсөвт 3 байгууллагын 2021 оны төсвийн төслийг орлогын төлөвлөгөөг 95.9 сая төгрөг, төсвийн зарлага 1.042.1 сая төгрөг байхаар боловсруулан цахим системд хуулийн хугацаанд оруулан ажиллалаа. Татварын орлогын төлөвлөгөө 8.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлхээс 1.3 сая төгрөгийн орлого төвлөрч гүйцэтгэл 16.3 хувьтай байна.

Санхүүгийн дэмжлэгээр 98.2 сая төгрөгийн санхүүжилт авахаас 01 дүгээр сарын 25-ний өдрийн байдлаар санхүүжилт олгогдоогүй байна.

Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагуудын санхүүжилт нийт 132.0 сая төгрөгийн санхүүжилт ирж нийт санхүүжилтийг олгон ажиллалаа.

Тайлант хугацаанд төсвийн тухай хуулийн дагуу төсөвт байгууллагууд 2020 оны санхүүгийн тайланг гарган 01 дүгээр сарын 25-ний өдрийн дотор төрийн аудитын газарт 100 хувь хүргүүлэн ажиллалаа.

ЕБС-ийн төгсөх ангийн элсэлтийн ерөнхий шалгалт өгөх 11 сурагчдад 6 судлагдахуунаар өдөрт 6 цагаар давтлага өгч байна. Нийт 27 багш ажилчид богинсогсон цагаар ажиллаж ээлжээр сумын төвөөр эргүүл хяналт шалгалт хийж байна. 2 цаг тутамд анги танхимд ариутгал халдваргүйжүүлэлт хийж, тухайн элсэлтийн ерөнхий шалгалтын давтлага бэлтгэгчдийн мэдээг тогмол БСУГ-т мэдээллэн ажиллаж байна.

ЭМТөвийн 2 их эмч болон дархлаажуулалтын бага эмч нар health.gov.mn веб сайтаар тусгай эрхээр нэвтрэн эрүүл мэндийн даатгалаар цахимаар хөнгөлөлттэй эмийн жороор нийт 142 иргэнд үйлчилгээ үзүүллээ. Нийт товлолын дархлаажуулалтад хамрагдсан 31 хүүхдийн мэдээллийг цахим жорын программд шивж оруулсан.

Сувилахуйн багаар өдрийн эмчилгээ 22 хүнд, сэргээн засах тусламж үйлчилгээ 2 хүнд, гэрийн тусламж үйлчилгээ 7 хүнд, 2 хэвтрийн өвчтөнд хөнгөвчлөх тусламж үйлчилгээ үзүүлж 4 төрлийн сувилахуйн тусламж үзүүлсэн.

Багийн байранд багийн эмч 3 хоног багийн төв дээр ажиллаж 2 өдөр гэрийн эргэлтээр ажиллаж 183 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн.

Мобайл ЭКГ, Мобайл ЭХО аппаратууд хэвийн ажиллаж, 2 эмч мэргэжилтнийг мобайл технологийн чиглэлээр мэргэшүүлэх сургалтанд хамруулж Мобайл ЭКГ 6 хүнд, Мобайл ЭХО аппаратаар 4 хүнд үзлэг хийж зөвөлгөө өгсөн.

Улаанбаатар хотод зохион байгуулсан ХБӨ-нөөс сэргийлэх мобель технологи нэвтрүүлэх сургалтанд 2 эмч хамрагдсан. Мөн арьсны оношлогооны чиглэлээр 1 өдрийн сургалтанд 1 их эмч хамрагдсан.

Мөн Орон нутгийн хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтанд 1 өрхийн эмч хамрагдсан. ЗДТГазрын цахим хуудсанд 8 төрлийн мэдээлэл байршуулахад 515 хүн хандаж мэдээлэл авсан байна.

Шинэ короновирусын халдвараас сэргийлье -615 хүнд

Гар угаах зөв дадал хэвшил-230 хүнд

Амны хаалтаа зөв сонгоцгооё – 158 хүнд нийт 1003 хүнд зөвөлгөө өгсөн.

ЭМТөвөөр үйлчлүүлсэн 720 үйлчлүүлэгчдэд видео хэлбэрээр сургалт сурталчилгаа явуулсан.

Тус сумын харъяалалгүй 317 ахмадын судалгаа гаргаж аймгийн ХХҮГ-т СЗДТГ-ын даргын 2021 оны 12 тоот албан бичгээр хүргүүллээ.

Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх зорилгоор ЖҮХ-с гаргасан зөвлөмжөөс холбогдох заалтыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулж тайланг, ЗДТГ-ын 13 тоот албан бичгийг АЗДТГ-т хүргүүлсэн.

Хүний эрхийн үндэсний комиссоос зохион байгуулсан “Хүчирхийлэгчийн зан үйлд нөлөөлөх сургалт явуулах сургагч багш бэлтгэх” 4 өдрийн сургалтад 2 албан хаагч хамаарагдаж сертификаттай боллоо.

2020 оны арьс ширний урамшуулалд хамрагдсан 116 малчны материалыг Дархан-Уул аймгийн ХХААГ-т хүргүүлэн, Мал хамгаалах сангийн програмд шивж орууллаа.

Тайлант сард ургамлын гаралтай, гарал үүслийн гэрчилгээг 5 иргэний 42тн 4 төрлийн хүнсний ногоонд олголоо. “BEST”-хөтөлбөрөөс зохион байгуулсан ЖДҮ-ийн бодлого. Төрийн худалдан авалт, тендерт оролцох боломж сэдэвт цахим сургалтад 2 ААНБ, 3 хоршоо, 3 иргэн нийт 8 иргэнийг хамрууллаа.

Аймгийн Тэргүүний тариаланчийн 1 тодорхойлолтыг аймгийн ХХААГ-т хүргүүллээ.

Сумын Засаг даргын 2020 оны А/164-р захирамжийн дагуу СХС-ийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах 4 иргэнээс хүсэлт авч, 3 иргэний 4.2 сая төгрөгний зээлийн эргэлтийг 2021 оны 6 дугаар сарын 01-ийг хүртэлх хугацаанд хойшлуулсан.

Сумын хэмжээнд 2021 оны 01 дүгээр сарын байдлаар сумын цагдаагийн хэсгээр үйлчлүүлсэн 25 иргэнд холбогдох хуулийн дагуу хууль зүйн зөвлөгөө өглөө. Иргэд ААНБ-аас зөрчлийн шинжтэй ахуйн хүрээний 5 дуудлага мэдээлэл хүлээн авч, зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, зөрчил гаргасан 5 иргэнийг бэлэн бус торгуулийн машинаар торгууль ногдуулж ажиллалаа.

Гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хариуцлагатай эргүүл томилон ажиллуулж архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг хүнсний дэлгүүрүүдэд давхардсан тоогоор 42 удаа хяналт шалгалт хийж, мөн харуул хамгаалалттай ААНБайгууллагад давхардсан тоогоор 20 удаа шалгаж, сонор сэрэмжтэй үүрэг гүйцэтгэх талаар зөвлөгөө өгч ажиллалаа.

Угтах үйлчилгээгээр 11 иргэнд 3 төрлийн мэдээлэл өгч, 34 иргэнд лавлагаа олгосон. Нотариатын үйлчилгээг нийт 18 иргэнд өглөө.

Аймгийн ОБГ-аас зохион байгуулсан, гэрийн тусгаарлалтад байгаа иргэдийг цахимаар хянах сургалтад, сумын шуурхай штабын 2 албан хаагч хамрагдаж, тайлант хугацаанд 16 иргэнийг гар утсанд нь тухайн GPS-р суулгаж хяналтад авсан байна.

Нууцын тооллого явуулах 2020 оны 12 дугаар сарын 23-ны А/23 тоот захирамжын дагуу нийт 66 нууц баримтыг жагсаалтыг гаргаж бүртгэв.

Энхтал багийн Цэргийн тоо бүртгэлийн 1 болон 2 дугаар үүрэгтэн 83 хувьтай байна. Цэргийн алба хаасан 50-аас дээш насны иргэдийн судалгаа цэргийн штабд явуулсан. Сумын Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн дарга хэсгийн төлөөлөгч, Багын засаг дарга нартай хамтран Орхон сумын хөдөө хэсгээр явж малчид иргэдийн өвөлжилттэй танилцаж малчин 37 өрхөөр орж санал хүсэлтийг авч ажиллаа. Иргэдээс малын тэжээл үнэтэй байна гэсэн саналууд гарлаа.

Сумын шуурхай штаб 24 цагаар 7 албан хаагч үүрэг гүйцэтгэж байна. Ойролцоо аймаг, сумын иргэд тээврийн хэрэгслийн зөвшөөрөлгүй нэвтрэлт аюулгүй байдалд хяналт тавих хөдөлгөөнт эргүүл томилон цагдаагийн 2, төрийн байгууллагын 7 албан хаагчийн хамт 24 цагийн үүрэг гүйцэтгэж байна. Мөн төв зам болон орж гарах хаалган дээр аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын хамтарсан 4 хүний бүрэлдэхүүнтэй 48/48 цагаар ээлжийн пост үүрэг гүйцэтгэж байна. 2021 оны 01 сарын

01-15-ыг хүртэлхи хугацаанд 0.95 сая төгрөгний шатахуун, 0.46 сая төгрөгний хоол хүнс, түлээ нүүрс зарцуулаад байна.

Нийт ААНБ-ын 119 албан хаагчаас 0-12 насны хүүхэдтэй 34 албан хаагч гэрээр ажиллаж, бусад албан хаагч богиносгосон цагаар ажиллаж байна. ЕБС-ийн 12 ангийн 11 хүүхдэд Элсэлтийн ерөнхий шалгалт өгөх сурагчидад хуваарийн дагуу давтлага халдвар хамгааллын дэглэмийн дор явагдаж байна. Сумын хэмжээнд ЕБС, СӨБ-ийн багш ажилчид нийт 38 албан хаагч, "School Police"-ийн 20 эцэг эх хамтран хуваарийн дагуу сумын төвөөр өдрийн цагаар хариуцлагатай эргүүл жижүүрийн үүрэг гүйцэтгэж байна.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР